



ГЛОБ ИНТЕРНЭШНЛ ТББ

Сүхбаатар дүүрэг 8, Соёлын төв өргөө, А байр 334 тоот. Утас: 324627, Факс: 324764,  
E-mail: [globe@magicnet.mn](mailto:globe@magicnet.mn), [globe@magicnet.mn](mailto:globe@magicnet.mn), [bayan@magicnet.mn](mailto:bayan@magicnet.mn)

## 2005 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн хэвлэл мэдээллийн мониторингийн хоёрдахь шатны дүн

2005 оны 5-р сарын 9

Глоб Интернэшнл ТББ нь үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалах, хөхүүлэн дэмжих чиглэлээр ажилладаг ба 2005 оны 5-р сарын 22-нд болох Ерөнхийлөгчийн сонгуультай холбогдуулж хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээлэлд системтэй ажиглалт хийхээр хэвлэл мэдээллийн мониторинг төслийг хэрэгжүүлж байна. Тус төсөл нь дэлхий нийтэд ардчиллыг хөгжүүлэх, дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг АНУ-ын Вашингтон хотод байрладаг Үндэсний Ардчилсан Хүрээлэнгийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж байна.

Глоб Интернэшнл байгууллага нь Монголын иргэдийг мэдээлэлтэй сонголт хийхэд нэр дэвшигчид болон тэдний мөрийн хөтөлбөрийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хэр бодитой, тэнцвэртэй мэдээлэл хүргэж байгааг үнэлэх зорилготой юм. Тус төслийн хүрээнд хийгдсэн мониторингийн үр дүн нь сайн, хянамгай боловсруулагдсан арга зүйнд тулгуурлаж хийгдсэн бөгөөд аливаа нэг нэр дэвшигч, улс төрийн намыг дэмжих зорилгогч юм.

Сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхэлсэн өдрөөс (4-р сарын 04) эхлэн зургаан телевиз (MVTB, 25-р суваг, UBS TV, TV9, Eagle TV), нэг радио (MYP), дөрвөн өдөр тутмын сонинд (Өдрийн сонин, Өнөөдөр, Зууны мэдээ, Ардын Эрх) дүн шинжилгээний тоон болон чанарын арга зүйг хэрэглэж ажиглалт хийлээ. Тоон дүн шинжилгээ нь хэвлэл мэдээллийн сонгуульд хамааралтай нийтлэл, нэвтрүүлгийн талбай, цаг хугацааг хэмжинэ. Чанарын дүн шинжилгээг тухайн мэдээлэл агуулгын хувьд эерэг, сөрөг эсвэл төвийг сахисан эсэхийг үнэлж дүгнэсэн юм.

Иргэдэд сонгуульд мэдээлэлтэй сонголт хийхэд хэвлэл мэдээлэл нь шаардлагатай мэдээллийг хүргэх үүрэгтэй. Тэд ихэвчлэн хэвлэл мэдээллээс хвлэж авсан мэдээлэл дээрээ тулгуурлаж саналаа өгдөг. Хэвлэл мэдээлэл юуг мэдээлж байгаа нь сонгуулийн үр дүнд чухал нөлөө үзүүлнэ. Тэд улс төрийн нам, нэр дэвшигчдийн талаар тэнцвэртэй болон шударга мэдээллийг хэр зэрэг дамжуулж байгаагаараа жинхэнэ чөлөөт сонгууль явуулахад ач холбогдлоо өгч чадна. Хэвлэл мэдээлэл хариуцлагатай болон шударга мэдээлэл дамжуулахын зэрэгцээ ялангуяа иргэдээс санхүүждэг төрийн эзэмшилд байгаа хэвлэл мэдээлэл нь сонгуульд нэр дэвшигч албан тушаалтны талаар нэг талыг барьсан мэдээлэл дамжуулах ёсгүй юм.

Одоогоор Глоб Интернэшнл байгууллагаас хоёр үе шаттайгаар /нэгдүгээр шат 4-р сарын 4-22/, /хоёрдугаар шат 4-р сарын 23-наас 5-р сарын 6/ мониторингийн дүн гаргаад байна. Энэ хугацаанд нэр дэвшигчид болон сонгуулийн кампанит ажлыг мэдээлэхдээ ХМХ-үүд нилээд ялгаа, зөрүүтэй байгааг олж тогтоолоо. Дараахь үр дүн нь Глоб Интернэшнл ТББ-аас 5 сарын 22-нд болох сонгууль хүртэл гаргах тайлангийн хоёрдахь нь юм.

### Гол үр дүн

- Ø Хоёрдахь шатны мониторингийн хугацаанд /4-р сарын 23-наас 5-р сарын 6/ телевизүүдийн ихэнх нь нэр дэвшигчдийн сонгуулийн кампанийг илүү тэнцвэртэй мэдээлсэн байна. Гэхдээ энэ тэнцвэрт байдал нь мэдээ, мэдээллийн стандартыг сайжруулсны дүнд бус харин ажиглалт хийгдэж буй телевиз, радио /Монголын Үндэсний Телевиз, Монголын Үндэсний радио, UBS, ТВ-9 болон ТВ-5/ болон нэр дэвшигчдийн хооронд байгуулсан байж болох ер бусын гэрээтэй холбоотой мэт санагдана.
- Ø Нэр дэвшигчдийн сонгуулийн штабаас бэлдсэн гэх бөгөөд мэдээллийн гол хөтөлбрүүдэд оруулсан /бараг бүгд Сонгууль -2005 гэсэн нэртэй/ булангуудаас бусад тохиолдолд нэр дэвшигчдийн сонгуулийн арга хэмжээ болон тэдний мөрийн хөтөлбөрийн талаар маш бага мэдээлж байна.
- Ø Мониторингд хамрагдсан сонинуудын хувьд аль нэг нэр дэвшигчийг дэмжсэн буюу эсэргүүцсэн байдлаар нэг талыг хүчтэй баримталсан мэдээлэл өгсөн хэвээр байна.

- Ø Монголын Үндэсний Телевизээр урьдчилсан байдлаар 5-р сарын 18-нд халз мэтгэлцээн явуулахаар бүх дөрвөн нэр дэвшигч тохиролцсон явдал эерэг зүйл боллоо. Телевизийн халз мэтгэлцээн нь нэр дэвшигчдийн дэвшүүлж буй сэдвүүд болон тэдгээрийн хоорондох ялгааг илүү сайн ойлгож сонголт хийх боломжийг иргэдэд хамгийн сайн олгодог хэлбэр юм.
- Ø Сонгуульд өрсөлдөгчдийн үзэл бодлыг бүрэн дүүрэн мэдэх, тэдгээрт дүн шинжилгээ өгч сонголтоо хийх боломжийг сонгогчдод олгоход чиглэсэн хэлэлцүүлэг явуулах, үзэл бодлыг уралдуулах, маргаан зөрчлийг эрэн сурвалжилж тайлбарлах талаар олон түмэнд үйлчлэх үүргээ Монголын ХМХ одоогийн байдлаар биелүүлж чадахгүй байна.

## **ТЕЛЕВИЗ**

Телевизүүдийн ихэнх нь нэр дэвшигчдийн сонгуулийн кампанийг илүү тэнцвэртэй мэдээлсэн байна. Гэхдээ энэ тэнцвэрт байдал нь мэдээ, мэдээллийн стандартыг сайжруулсны дүнд бус харин ажиглалт хийгдэж буй телевиз, радио болон нэр дэвшигчдийн хооронд өвөрмөц гэрээ байгуулсан явдалтай холбоотой гэмээр харагдаж байна. Ийнхүү тохиролцсоны дагуу дөрвөн нэр дэвшигч мэдээллийн гол хөтөлбөрт өөрсдийн талаар мэдээлэл өгч үүнийхээ төлөө төлбөр төлж байгаа бололтой. Өдөр бүр сонгуулийн штабууд нэр дэвшигчдийнхээ талаар сурталчилсан материал бэлтгэж тэдгээрийг нь телевизүүд болон радиод үндсэндээ засаж найруулалгүйгээр мэдээний цагаар нэвтрүүлж байна. Энэ нь Зар сурталчилгааны тухай Монгол улсын хуулийн заалтуудыг /11.3 болон 18.1/ зөрчөөд зогсохгүй сэтгүүл зүйн мэргэжлийн ёс зүйд огт нийцэхгүй зүйл юм.

### *Монголын Үндэсний Телевиз /МҮТВ/*

Хоёрдахь шатны мониторингийн хугацаанд нэр дэвшигчийн үйл ажиллагаа болон тэдгээрийн талаархи байр суурийг харуулсан мэдээллийн цаг МАХН-аас нэр дэвшигч Н.Энхбаярын хувьд 55%-аас 24% болтлоо ихээхэн буурсан байна. Гэхдээ түүнийг ихэвчлэн эерэг буюу төвийг сахисан байдлаар харуулсан, түүгээр ч барахгүй бүх нэр дэвшигчдийн дотроос тэрбээр хамгийн их эерэг үнэлгээ авсан байна. Цаашилбал нэр дэвшигчдид өөрийн үзэл бодлыг сонгогчдод хүргэж эфирт шууд гарсан цагийн ихэнх нь Н.Энхбаяр оногдож байна. Нөгөө талаар, хоёрдахь шатны мониторингийн хугацаанд МҮТВ-ээр Н.Энхбаярыг УИХ-ын даргын хувиар харуулах явдал ихээхэн багассан байна. Үүнтэй харьцуулахад эхний шатны мониторингийн хугацаанд УИХ-ын дарга болон нэр дэвшигчийн хоорондох ялгаа зарим төрийн болон хувийн ХМХ-д ихээхэн бүрхэг байсныг хэлэх хэрэгтэй. Нэр дэвшигч М.Энхсайханы талаархи мэдээлэл 22%-аас 20% болж багассан бөгөөд ихэнхдээ эерэг буюу төвийг сахисан байв. Хоёрдахь шатны мониторингийн хугацаанд МҮТВ-д хамгийн их мэдээлэгдсэн нэр дэвшигч бол Б.Эрдэнэбат байсан бөгөөд эерэг буюу төвийг сахисан мэдээлэл зонхилж 32%-тай байв. Мөн хугацаанд Б.Жаргалсайханы талаар мэдээлсэн байдал

Нэр дэвшигчдийн сонгуулийн штабаас бэлдсэн гэх бөгөөд мэдээллийн гол хөтөлбөрт оруулсан /Сонгууль -2005 гэсэн нэртэй/ булангаас бусад тохиолдолд нэр дэвшигчдийн сонгуулийн арга хэмжээ болон тэдний мөрийн хөтөлбөрийн талаар МҮТВ маш бага мэдээлж байна. Үүгээр зогсохгүй хэлэлцүүлэг явуулах, үзэл бодлыг чөлөөтэй уралдуулан олон түмэнд үйлчлэх үүргээ энэ телевиз биелүүлсэнгүй.

### *UBS телевиз*

Өмнөх хугацааны мониторингой харьцуулахад UBS телевиз нэр дэвшигчдийн сонгуулийн кампанит ажлыг хавьгүй илүү тэнцвэртэйгээр мэдээлжээ. МАХН-ын нэр дэвшигч Н.Энхбаярын талаархи мэдээлсэн хувь огцом буурч 79%-аас 30% болсон. Энэ нэр дэвшигчийн талаархи мэдээ нь бvхэлдээ эерэг буюу төвийг сахисан байсан бөгөөд тодорхой хэмжээний шүүмжлэлтэй зүйл гарч байв /эхний шатны мониторингд ийм байгаагүй/. УИХ-ын даргын хувиар Н.Энхбаяр UBS телевизээр 3 минут 12 секунд шууд мэдээлэгдсэн байна. Түүний дараа хамгийн их мэдээлэгдсэн нэр дэвшигч бол БНН-аас нэр дэвшигч Б.Жаргалсайхан бөгөөд түүний талаархи мэдээлэл 28 хувийг эзэлсэн ба гол төлөв эерэг өнгө аястай байжээ. Бусад хоёр нэр дэвшигч буюу АН-аас нэр дэвшигч М.Энхсайханы талаархи мэдээлэл 22%, Эх-Орон Намаас нэр дэвшигч Б.Эрдэнэбатын талаарх мэдээлэл 20%-ийг тус бүр эзэлжээ. UBS телевизийн зарим мэдээлэл нэг талыг барьсан байв. Жишээ нь:

- *UBS телевизийн 5-р сарын 1-ний 20:30 цагийн мэдээллийн хөтөлбөрт нэр дэвшигч Н.Энхбаяр Ерөнхий сайд байх үедээ дотоодын үйлдвэрлэлийг дэмжих талаар их зүйл хийсэн гээд харин М.Энхсайханы үед*

*импортын гаалийн татварыг тэглэсэн нь улс орныг доройтуулж, ядуурлыг нэмэгдүүлсэн гэв. Энэ нь нэг талыг сөргөөр, нөгөөг эерэгээр харуулсан атлаа буруутгагдсан талын байр суурийг сонсоогүй байдлыг илтгэнэ.*

- *UBS телевизийн 5-р сарын 1-ний 20:30 цагийн мэдээллийн хөтөлбөрт сурвалжлагч хүмүүсээс ярилцлага авч Орост төлсөн их өрийн талаар асуухад Н.Энхбаяр өрийн асуудлыг шийдэхэд их үүрэг гүйцэтгэсэн гэсэн дан эерэг харцултыг үзүүлээд, өөр үзэл бодол гарсангүй.*

### **Ийгл телевиз**

Ийгл телевизийн мэдээний нэвтрүүлгүүд сонгуулийн кампаний талаар үзэгчдэд хамгийн тэнцвэртэй дүр зургийг хүргэж байв. Мониторингийн дүнг харвал: АН-аас нэр дэвшигч М.Энхсайхан – 26%, БНН-аас нэр дэвшигч Б.Жаргалсайхан – 30%, Эх-Орон Намаас нэр дэвшигч Б.Эрдэнэбат 19%, МАХН-аас нэр дэвшигч Н.Энхбаяр 25% байна. Тус телевизээр бүх нэр дэвшигчдийн талаар мэдээлэл ерөнхийдөө эерэг мэдээлэл нь сөрөг мэдээлэлээсээ давамгайлж байгаа бөгөөд сөрөг талаасаа хамгийн их гарсан нь Н.Энхбаяр байна.

### **TV-5**

TV-5 мониторингийн эхний шатанд тэнцвэргүй мэдээлж байсан байдал нь дахин давтагдав. Гэхдээ эхлээд МАХН-ын нэр дэвшигч Н.Энхбаярт илүү талтай байсан бол одоо Эх-Орон Намаас нэр дэвшигч Б.Эрдэнэбатыг илэрхий дэмжжээ. Тэрбээр түүний талаар зөвхөн эерэг буюу төвийг сахисан мэдээлэл, нэвтрүүлэг нийт нэр дэвшигчдийн цагийн 61%-ийг эзэлсэн байна. Түүнээс гадна нэр дэвшигчдид өөрийн үзэл бодлыг сонгогчдод хүргэж эфирт шууд гарсан цагийн ихэнх нь буюу 18 минут 37 секунд Б.Эрдэнэбатад оногджээ. Түүний дараа хамгийн их мэдээлэгдсэн нэр дэвшигч бол Н.Энхбаяр бөгөөд тэрбээр 17%-тай байгаа нь өмнөх мониторингтой харьцуулахад /47%/ эрс буурсан бөгөөд нийтдээ өнгө аяс нь эерэг буюу төвийг сахисан байлаа. Үлдсэн хоёр нэр дэвшигч - М.Энхсайхан, Б.Жаргалсайхан нар 12% ба 10% тус бүр оногдсон байна. Тэдний талаархи мэдээллийн өнгө аяс бүхэлдээ эерэг буюу төвийг сахисан байлаа.

- *Сонгуулийн кампани эхэлснээс хойш нэр дэвшигч Б.Эрдэнэбат тус телевизийн “Монгол улсаа хөгжүүлэе” нэвтрүүлэгт гурван удаа оролцжээ. Эхлээд 4-р сарын 24-нд хувь хүн, бизнесмен гэдэг утгаар, дараагийн өдөр нь өөрийн мөрийн хөтөлбөрөө танилцуулж, мөн саявтархан 5-р сарын 4-нд нэр дэвшигчийн хувьд Дархан хотыг хөгжүүлэх талаар тус тус ярьсан байна. Одоогоор түүнээс бусад нэр дэвшигч энэ нэвтрүүлэгт оролцоогүй байгаа.*
- *TV-5 мэдээнийхээ нэвтрүүлгээр Дэлхийн чөлөөт хэвлэлийн өдрөөр УИХ-ын дарга Н.Энхбаяр сэтгүүлчидтэй уулзсан тухай мэдээлэхэд Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн эвлэлийн ерөнхийлөгч /тус телевизийн захирал/ Д.Сарангэрэл түүнд хадаг, сүү барьж сонгуулийн ажилд нь амжилт хүсэж байгаагаар мэдээлсэн*

### **ТВ-9**

Мониторингийн хоёрдахь шатанд TV-9 телевизийн үзэгчид МАХН-аас нэр дэвшигч Н.Энхбаярын талаар мэдээлэл илүү авсан хэвээр /36%/ байсан боловч тус нэр дэвшигчийг олон нийтэд танилцуулах явдал түрүүчийн мониторингийн үеэс /69%/ ихээхэн буурсан байна. Н.Энхбаярын талаархи мэдээллийн дийлэнх нь түүнийг эерэг талаас нь харуулсан болон төвийг сахисан мэдээлэл байв. Мөн хугацаанд АН-аас нэр дэвшигч М.Энхсайханы талаар мэдээлэл хамгийн бага /17%/ байсан ба ихэнх нь төвийг сахисан буюу эерэг мэдээлэл байв. Эх-Орон Намаас нэр дэвшигч Б.Эрдэнэбатын талаар мэдээлэл 29%, БНН-аас нэр дэвшигч Б.Жаргалсайханы талаар мэдээлэл 18%-ийг эзэлж байна.

- *Тус телевиз 4-р сарын 25-н болон 5-р сарын 1-нд “Буян” компаний /нэр дэвшигч Б.Жаргалсайхан захирал нь байсан/ Марубени корпорацид төлөх өрийн талаар шүүмжлэлтэй мэдээлсэн боловч нэр дэвшигчээс юмуу тус компаний төлөөлөгчөөс байр суурийг нь сонсоогүй байна.*
- *TV-9 телевизийн мэдээллийн гол хөтөлбөрт нэр дэвшигч М.Энхсайханыг Ерөнхий сайд байх үедээ импортын гаалийн татварыг тэглэж жижиг дунд үйлдвэрлэгчдийг хохироож байсан талаар хэлээд, харин Н.Энхбаяр Ерөнхий сайд байхдаа дээрх шийдвэрийг цуцалсанаар маш эерэг сайн зүйл хийсэн гэв. Буруу шийдвэр гаргасан М.Энхсайханы үгийг сонсоогүй.*

## **25-р суваг телевиз**

АН-аас нэр дэвшигч М.Энхсайханы талаар сайн талаас нь мэдээлсэн ганц телевиз бол 25-р суваг байлаа. Үүний зэрэгцээ энэ телевиз нэр дэвшигч Н.Энхбаярын талаар хамгийн их сөрөг мэдээлэлтэй байв. Сонгуулийн кампаний өнгөрөгч хоёр долоо хоногт М.Энхсайханы талаархи мэдээлэл ихээхэн буурч 87%-аас 25% болсон байна. Гэтэл мэдээллийн цагийн өсөлт оногдсон Н.Энхбаярын хувьд энэ тоо 9%-аас 40% болжээ. Б.Эрдэнэбат /30%/ -ын талаархи мэдээ бүхэлдээ эерэг буюу төвийг сахисан бол Б.Жаргалсайханыг /5%/ төвийг сахисан буюу сөрөг талаас нь харуулсан байна.

## **Монголын Үндэсний Радио /МҮР/**

Монголын Үндэсний Радио нь сонгуулийн талаархи мэдээллийн цагийг дөрвөн нэр дэвшигчид хуваарилсан байдлыг харвал: МАХН-аас нэр дэвшигч Н.Энхбаярын талаар мэдээлэл 28%-аас 6% болтлоо буурсан бөгөөд мэдээллийн өнгө аяс нь гол төлөв төвийг сахисан буюу эерэг боловч сөрөг мэдээлэл бас байв. Нэр дэвшигч М.Энхсайхан, Б.Жаргалсайхан нар бараг ижил хэмжээтэй мэдээлэгдэж 31% ба 28% тус тус авчээ. Мониторингийн хоёрдахь шатанд МҮР-гоор эерэг буюу төвийг сахисан байр сууринаас хамгийн их яригдсан хүн бол Эх-Орон Намаас нэр дэвшигч Б.Эрдэнэбат /41%/ байв. Эерэг өнгө аястай мэдээллийн ихэнх хувь нэр дэвшигч М.Энхсайханд оногдсон байна.

- *МҮР-гоор сонгуулийн талаар мэдээлэхдээ эх сурвалжуудыг хачирхалтай байдлаар нэрлэж байв. Заримдаа “намын хэвлэл мэдээллийн алба”, зарим тохиолдолд “/манай/ тусгай сурвалжлагч”, бас ихэнхдээ хаанаас мэдээлснийг огт дурдалгүй мэдээгээ уншаад явдаг /5-р сарын 3,4,5,6-ны өдрийн 22:00 цагийн мэдээ/.*
- *Мэдээ гэхээсээ илүү суртал нэвтрүүлгийн чанартай магтаал нэвтрүүлж байна. Тухайлбал 5-р сарын 5-ны 22:00 цагийн мэдээгээр нэр дэвшигч Н.энхбаярыг Хэнтий аймаг зочлох үеэр Их Эзэн Чингисийн нутгаас 800 жилийн дараа төрийн тэргүүн сонгогдох гэж байна гэж нэвтрүүлсэн /нэр дэвшигчийн эеж Хэнтий аймгийн Дадал сумын хүн учраас тэгсэн гэнэ/.*

## **СОНИН**

Мониторингд хамрагдсан сонинуудын хувьд аль нэг нэр дэвшигчийг дэмжсэн буюу эсэргүүцсэн байдлаар нэг талыг хүчтэй баримталсан мэдээлэл өгсөн хэвээр байна. Иймээс олон сонины нийтлэлийг уншиж байж л сонгуулийн кампаний талаар бодит ойлголттой болох нь.

### **“Ардын эрх”**

“Ардын эрх” сониноор нийт нэр дэвшигчидтэй холбоотой нийтлэлийн зайны 36% нь АН-аас нэр дэвшигч М.Энхсайханы тухай байсан ба түүнтэй холбоотой мэдээллийн эерэг өнгө аяс нь сөрөгтэйгээ тэнцүүхэн байлаа. Түүний гол өрсөлдөгч МАХН-аас нэр дэвшигч Н.Энхбаярын талаар мэдээлэл 27%-ийг эзэлж байгаа ба түүний талаар сөрөг мэдээлэл нь эерэг мэдээллээс ялимгүй илүү байна. Үлдсэн хоёр нэр дэвшигчийн талаар гол төлөв төвийг сахисан буюу сөрөг мэдээлэл гарч Эх-Орон Намаас нэр дэвшигч Б.Эрдэнэбат 7%-тай ба БНН-аас нэр дэвшигч Б.Жаргалсайханы талаархи мэдээлэл 30%-ийг эзэлжээ.

### **“Өнөөдөр”**

“Өнөөдөр” сонины нэр дэвшигчтэй холбоотой нийтлэлийн 53% нь Эх-Орон Намаас нэр дэвшигч Б.Эрдэнэбатад зориулагдаж өнгө аяс нь гол төлөв төвийг сахисан буюу эерэг байв. Мэдээлэгдсэн хэмжээгээрээ түүний дараа орох нэр дэвшигч бол Н.Энхбаяр /36%/, түүний ард М.Энхсайхан /14%/ байна. Б.Эрдэнэбатын тухай эерэг мэдээлэл нь сөрөгөөсөө илүүтэй байгаа бол бусад гурван нэр дэвшигчийн талаархи мэдээлэл үүний эсрэгээр байв.

### **“Өдрийн сонин”**

“Өдрийн сонин” нэр дэвшигчтэй холбоотой өөрийн нийтлэлүүдийн 51%-ийг Н.Энхбаярт зориулсан боловч тэдгээрийн өнгө аяс нь төвийг сахисан буюу сөрөг байна. Харин түүний гол өрсөлдөгч АН-аас нэр дэвшигч М.Энхсайханы талаар бүхэлдээ төвийг сахисан болон эерэг талаас нь харуулсан болон мэдээлэл нийт сонгуулийн нийтлэлийн 21%-ийг эзэлж байна. Бусад хоёр нэр дэвшигчээс Б.Эрдэнэбатын талаар илүүтэй /23%/ мэдээлсэн ба Б.Жаргалсайхан дөнгөж 9%-тай байна. Энэ хоёрын талаар төвийг сахисан буюу сөрөг талаас нь мэдээлжээ.

#### “Зууны мэдээ”

“Зууны мэдээ” сонин МАХН-аас нэр дэвшигч Н.Энхбаярыг хүчтэй дэмжсэн хэвээр байна. Тэрбээр нийт нэр дэвшигчдэд хуваарилагдсан талбайн 75%-ийг дангаараа эзэлж мэдээлэл нь дийлэнхдээ төвийг сахисан болон эерэг байна. Харин үүний эсрэгээр, АН-аас нэр дэвшигч М. Энхсайханы талаар мэдээлэл 15%-ийг эзэлж эдгээр нь ихэнхдээ нейтрал буюу сөрөг талын мэдээлэл байв. Бусад хоёр нэр дэвшигч болох Б.Эрдэнэбатын талаар мэдээлэл 2%, мөн Б.Жаргалсайханы талаар бичсэн мэдээлэл 8% тус тус байна.

#### ДҮГНЭЛТ

Глоб Интернэшнл ТББ-аас явуулсан хэвлэл мэдээллийн мониторингийн хоёрдахь шатанд цуглуулсан мэдээлэл нь Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийг мэдээлсэн цаг, зай талбай болон мэдээллийн өнгө аясын хувьд нилээд ялгаатай байгааг олж илрүүлэв. Мониторингийн хоёрдахь шатанд /4-р сарын 23-наас 5-р сарын 6-ны хооронд/ телевиз, радиогийн ихэнх нь улс төрийн хүчнүүдээс нэр дэвшигчдийн талаар илүү тэнцвэртэй мэдээлсэн байна. Гэхдээ энэ тэнцвэрт байдал нь мэдээ, мэдээллийн стандартыг сайжруулсны дүнд бус харин ажиглалт хийгдэж буй телевиз, радио болон нэр дэвшигчдийн хооронд өвөрмөц гэрээ байгуулсан явдалтай холбоотой гэмээр харагдаж байна. Сонгуулийг мэдээлэхдээ тэнцвэртэй, шударга байх зарчмуудыг ХМХ-үүд нийт жигд хангаж чадахгүй байгаа талаар эхний үеийн ажиглалтын маань хоёрдахь шатанд батлагдаж байгаа нь Монголын хэвлэл мэдээллийн хувьд дээрх байдал нь түр зуурын үзэгдэл бус бодит хандлага юм гэдгийг харуулж байна. Хэд хэдэн ХМХ Монголын сонгогчдод эсрэг тэсрэг байр суурийг хүргэх үүргээ ихэнхдээ умартаж байгаа нь амьдрал дээр харгдаж байна. Сонгуульд өрсөлдөгчдийн үзэл бодлыг бүрэн дүүрэн мэдэх, тэдгээрт дүн шинжилгээ өгч сонголтгоо хийх боломжийг сонгогчдод олгоход чиглэсэн хэлэлцүүлэг явуулах, үзэл бодлыг уралдуулах, маргаан зөрчлийг эрэн сурвалжилж тайлбарлах талаар олон түмэнд үйлчлэх үүргээ Монголын ХМХ одоогийн байдлаар биелүүлж чадахгүй байна. Энэ байдал тууштай оршиж байгаа эсэхийг тодорхойлохын тулд бид сонгууль хүртлэх хугацаанд тоо баримтаа цуглуулах ажлыг үргэлжлүүлэх болно.



\* \* \*

# 2005 оны Ерөнхийлөгчийн сонгууль



Монголын үндэсний телевиз - Мэдээ, нийгэм улс төрийн нэвтрүүлэг

23/04/05-06/05/05





# 2005 оны Ерөнхийлөгчийн сонгууль



Еagle телевиз - Мэдээ, нийгэм улс төрийн нэвтрүүлэг

23/04/05-06/05/05





# 2005 оны Ерөнхийлөгчийн сонгууль



## TV-5 телевиз - Мэдээ, нийгэм улс төрийн нэвтрүүлэг

23/04/05-06/05/05







# 2005 оны Ерөнхийлөгчийн сонгууль



UBS телевиз - Мэдээ, нийгэм улс төрийн нэвтрүүлэг

23/04/05-06/05/05





# 2005 оны Ерөнхийлөгчийн сонгууль



25 дугаар суваг телевиз - Мэдээ, нийгэм улс төрийн нэвтрүүлэг

23/04/05-06/05/05





# 2005 оны Ерөнхийлөгчийн сонгууль



TV-9 телевиз - Мэдээ, нийгэм улс төрийн нэвтрүүлэг

23/04/05-06/05/05





# 2005 оны Ерөнхийлөгчийн сонгууль



Монголын үндэсний радио - Мэдээ, нийгэм улс төрийн нэвтрүүлэг

23/04/05-06/05/05







# 2005 оны Ерөнхийлөгчийн сонгууль

## Өнөөдөр

4/23-5/6-2005







# 2005 оны Ерөнхийлөгчийн сонгууль

## Өдрийн сонин

4/23-5/6-2005







# 2005 оны Ерөнхийлөгчийн сонгууль

## Зууны мэдээ

4/23-5/6-2005





# 2005 оны ерөнхийлөгчийн сонгууль

## Ардын эрх

4/23-5/6-2005

